



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41. Утас: 7011-0251. Факс: (976) 7011-0251.  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2018.04.24 № 05/3562  
танай 2018.04.16 ны № 1/563 -г


Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Эрчим хүчний зохицуулах хорооны Төв аймгийн зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүний үүрэгт ажлыг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Баттулгын Энхтүвшингийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Харин аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүний ажлын байрны тодорхойлолтод эрчим хүчний инженер эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн техник-эдийн засгийн тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийх чиглэлээр мэргэшсэн, мэргэжлээрээ 2-оос дээш жил ажилласан байх гэж заасан байхад Б.Энхтүвшин нь дээрх шаардлагыг хангаагүй байна.

Иймд тус албан тушаалд хууль тогтоомж болон, ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагад нийцсэн этгээдийг нэр дэвшүүлэн томилохыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

 Х.ХАШБААТАР